

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
/2021 оны жилийн эцсийн байдлаар/**

НЭГ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Эрх зүйн актын биелэлтийн хувийг тооцохдоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон ашигласан болно.

Эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

3.1. Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо

ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд 2021 оны жилийн эцсийн байдлаар байршуулсан яамны үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ болон Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, тэмдэглэл нийлсэн нийт 115 тогтоол, шийдвэрийн 211 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

3.2. Үнэлгээний дундаж дүн

Хяналтад авсан 211 заалтын 187 нь “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн үнэлгээтэй, 22 заалт “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн ба биелэлтийн дүн дунджаар 96,8 хувьтай үнэлэгдэв.

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэгдсэн дүн
/2021 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

Бүгд		Шийдвэрийн төрлөөр										
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	115	9	22	7	1	4	2	28	4	36	2	
Заалтын тоо	211	39	32	10	1	6	8	37	4	68	6	
Үнэлгээ	Биелсэн /100%/	187	38	28	10	-	5	5	32	4	59	6
	Хэрэгжих шатанд /70%/	22	1	4	-	1	1	3	4	-	8	-
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	2	-	-	-	-	-	-	1	-	1	-
Үнэлгээ /хувь/	96,8	99,2	96,2	100	70	95	88,7	96,6	100	96,3	100	

Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан нийт 114 хууль тогтоомжоос 2021 онд 51, 2020 онд 17, 2019 онд 14, 2018 онд 11, 2010-2017 онд 22 тус тус батлагдсан байна.

Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	Нийт хяналтанд авсан	2021	2020	2019	2018	2010-2017
		115	51	17	14	11

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 96,8 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

4.2. Барилга, хот байгуулалтын салбарт хийгдэж буй зураг төсөл, худалдан авах ажиллагаа, хот төлөвлөлтийн ажилтай холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа харьцангуй шуурхай хийгдэж байгаа нь ажлын явц, үр дүнгээс харагдаж байна.

4.3. Барилга, хот байгуулалтын яаманд 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш ирсэн 62 тогтоол шийдвэрийн 84 заалт тус бүрт хяналтын карт хөтлөн холбогдох газар, хэлтсийн даргад хүлээлгэн өгч улирал бүр биелэлтийг авч байнгын хяналт тавин ажилласны үр дүнд хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, үр дүнг тооцоход тодорхой ахиц гарсан.

4.4. Нэг удаагийн шинж чанартай, хэрэгжиж дууссан тогтоол шийдвэрүүдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаас хасуулах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021 оны 09 дүгээр сард цахимаар хүргүүлж ажилласны үр дүнд Засгийн газрын 9 тогтоолын 14 заалт, Засгийн газрын хуралдааны 10 тэмдэглэлийн 15 заалтыг тус тус хяналтаас хасуулсан.

4.5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид дурьдсан 30 хувийн үнэлгээтэй заалтуудыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг ахиулсан. Үүнд:

- УИХ-ын “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” 2013 оны 23 дугаар тогтоол.

Заалт: 2.5. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөрдөн ажиллаж, биелэлтийг хоёр жил тутам гаргаж Улсын Их Хуралд танилцуулж байх. Хэрэгжилт: 70%

- УИХ-ын “Улсын бүртгэлийн багц хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 54 дүгээр тогтоол.

Заалт: 1.1. Иргэний хуулийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлэн Газрын тухай болон Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн төслийг 2019 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Хэрэгжилт: 100%

4.6. Барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийх зэрэг арга хэмжээний хөрөнгө санхүүжилт шийдэгдээгүйгээс шалтгаалан арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүрч байна. Иймд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээрх зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

4.7. Хяналтад авч хэрэгжилтийг тооцсон хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс хэрэгжих шатандаа буюу 70 хувийн хэрэгжилттэй 19 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 22 заалт байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. ХШҮ-ний нэгдсэн дүнгээр 70 хувийн үнэлгээтэй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нарт;

5.2. “Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрэм”-ийг батлуулж ажиллахыг ББМҮБХЗГ-т;

5.3. Барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийх ажлыг эрчимжүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллахыг ББМҮБХЗГ, СХОГ-т;

5.4. Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны Б/78 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарь”-ийг мөрдөж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нарт;

5.5. Нэг удаагийн шинж чанартай, хугацаа дууссан, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн болон цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ХШҮДАГ-тай хамтарч ажиллаж хэвшихийг яамны газар, хэлтсийн дарга нарт тус тус зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

